



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 8/13710508

Улаанбаатар хот

НТАГ-2025/155/НА-СТА-Тшз

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 87,152.00 (наян долоон мянга нэг зуун тавин хоёр) төгрөгийн шатахуун илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцээгүй, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар баталсан "Автомашинь 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3. "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.6 "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв шатахуун илүү зарцуулсан зөрчлийн 87,152.00 (наян долоон мянга нэг зуун тавин хоёр) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ хүү орлогын 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газар-1-т ирүүлэхийг Нийслэлийн Зоонозын өвчин судлалыг төвийн дарга М. Мөнгөнцэцэг, нягтлан бодогч Р. Саранцэцэг нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

МЭДЭЭЛЭЛ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Д.ТОВУУДОРЖ

ХЯНАСАН:

САНХҮҮ НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02051143